

"Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй ил тод байдал" мониторингийн 1-р шатны тайлан

Гарчиг

1. Мониторингийн арга зүй

- 1.1 Мониторингийн шаардлага
- 1.2 Мониторингийн зорилго
- 1.3 Мониторингийн зорилт
- 1.4 Мониторингийн зохион байгуулалт

2. Мониторингийн аргачлал

- 2.1 Мэдээлэл бүрдүүлэх аргууд
- 2.2 Хамрах хүрээ, хугацаа

3. Мониторингийн үр дүн:

- 3.1 Шууд утасны /1977/ судалгааны үр дүн
- 3.2 Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжийг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт
- 3.3 Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт
- 3.4 Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах чиглэлээр хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

4. Дүгнэлт

Хавсралт

- Авлигатай Тэмцэх Газрын зөвлөмж
- Ажиглалтын судалгааны харьцуулсан мэдээлэл
- Зөвлөмжийн хэрэгжилт сул байгууллагууд

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

1.1 Мониторингийн шаардлага

Ардчилсан төр засаг нь ардчилсан нийгмийн эрхэм үнэт зүйлс болох эрх чөлөө, тэгш эрхийг иргэддээ олгох гол тулгуур механизм болдог бөгөөд энэхүү механизмыг хөдөлгөгч хүчний салшгүй нэг хэсэг бол төрийн байгууллагын нээлттэй ил тод байдал юм.

Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 17 дахь хэсэгт ч мөн “Төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих, нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” хэмээн заасан байдаг.

Харин 2002 онд ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ шилжилтийн үеийн Монгол улсын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол улсын хуулиудад олон улсын 19-р зүйл (ARTICLE19) байгууллагатай хамтран хийсэн анализын тайланд, “Монгол улсын төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй байдал хангалтгүй байгаа нь гол бэрхшээл юм” гэж тэмдэглэжээ.

Гэтэл энэ гол бэрхшээл улс орны хөгжлийг сааруулагч авлигын олон хэлбэрүүдийн нэг бөгөөд манай улсад нэгэнт нүүрлээд байгаа авлигыг цэцэглүүлэгч хөрс суурь болоод байгаа тул Авилгалтай Тэмцэх Газараас /цаашид АТГ гэх/ “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, улмаар авилгаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах” талаар дурдсан 18 зүйл бүхий зөвлөмжийг 2007 оны 4-р сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн билээ.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагын /Глоб Интернэшнл/ зүгээс хийж буй “Төрийн байгууллагын нээлттэй, ил тод байдлын мониторинг” төслийг АТГ-ын захиалга, Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хагас жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж байна.

1.2 Мониторингийн зорилго

АТГ-аас гаргасан зөвлөмжийн дагуу Төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бодит мэдээлэлтэй болох, уг мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн санал бүхий ерөнхий зөвлөмж боловсруулахад оршино.

1.3 Мониторингийн зорилт

- АТГ-аас гаргасан зөвлөмжийн хүртээмж, хэрэгжих боломж нөхцөлд үнэлгээ өгөх
- Зөвлөмжийн хэрэгжилтийн түвшинг тогтоох, төрийн байгууллагад мэдээлэл ил тод, нээлттэй байгаа эсэхийг тодорхойлох
- АТГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд учирч буй саад бэрхшээл, шалтгаан нөхцөлийг илрүүлэх

- Төрийн байгууллагуудын үйлчилгээний ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах, иргэдийн оролцоог хангахын тулд цаашид шийдвэрлэх арга замыг олох

1.4 Мониторингийн зохион байгуулалт

Мониторингийн баг бүрдүүлэх

Мониторингийн баг нь анализийн баг, тандах судалгааны баг гэсэн бүтцээр ажиллаж байна. Арга зүй, анализийн баг нь зөвлөх, хоёр судлаачийн бүрэлдэхүүнтэй. Тандах судалгааны баг нь мэдээлэл цуглуулах 11 мониторингч, мэдээлэл оруулах, боловсруулах хоёр мониторингч, шууд утсаар мэдээлэл хүлээн авах нэг мониторингч, төслийн зохицуулагч, нийт 18 гишүүнтэй ажиллаж байна.

Мониторингийн арга зүй боловсруулах, арга зүйн сорил

Мониторингийн арга зүйг анализийн баг 2007 оны 7 сард багтаан, анкет, асуулга бүрийг боловсруулж сорил хийн, анкетуудыг эцэслэн боловсруулав.

Мониторч бэлтгэх нэг өдрийн сургалт

Мониторингийн мэдээлэл цуглуулах, боловсруулах дадлага, чадвар эзэмшүүлэх нэг өдрийн сургалтыг 2007 оны 8 сарын 11-ний өдөр зохион байгуулав.

- “Глоб Интернэшнл” ТББ, тэргүүн Х.Наранжаргал төслийн танилцуулга, үндэслэл
- Хуульч Г.Даваахүү “Нийтэд ил тод байх мэдээлэл, түүний хууль зүйн үндэслэл”
- Хуульч Д.Мөнхбүрэн “Авлига гэж юу вэ? Түүний түгээмэл хэлбэрүүд”
- Авлигатай тэмцэх газрын ахлах ажилтан Х.Доржпалам “Төрийн байгууллагуудын чиг үүрэг. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн мөн чанар, агуулга”
- Судлаач Г.Цогтбаатар “Социологийн судалгааны арга зүй ба үр дүнгийн үзүүлэлт, Ил тод байдлын судалгааны хүрээ, онцлог, мөн чанар, мониторингийн аргачлал, Судалгааны маягтын дагуу мэдээллийг хэрхэн үр дүнтэй, бүрэн” зэрэг сэдвүүдээр тус тус хичээл заасан.

2. МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мэдээлэл бүрдүүлэх аргууд

Ажиглалтын судалгаа: Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагууд иргэдэд шаардлагатай мэдээллийг хэр зэрэг хүртээмжтэй түгээж байгааг тодруулах зорилгоор зөвлөмж бичгийг дотор нь нэг бүрчлэн нарийвчлан задалж, асуулт боловсруулсны дагуу байгууллагуудад ажиглалт хийлээ.

Сурвалжилгын судалгаа: Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудад ажиллаж буй ажилтан, албан тушаалтнуудаас тухайн байгууллагад АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж хэрэгжиж байгаа эсэхийг асууж лавлан, хэрэв хэрэгжиж байгаа бол ямар түвшинд байгаа, үгүй бол яагаад гэдгийг тодруулсан болно.



Бичиг баримтын шинжилгээ: Төрийн үйлчилгээний байгууллагууд иргэдэд хүргэх үйлчилгээний талаарх тараах материал болон Вэб сайт дахь мэдээллүүд зэргийг нь судлан үзэж бичиг баримтын судалгааг хийв.

Шууд утас ажиллуулах: Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдалтай холбоотой иргэдээс гомдол, санал хүлээн авах шууд утас ажиллуулж байна.

Мониторингийн хүрээ

Мониторинг хийх төрийн байгууллагын тоог анх төлөвлөснөөс 2 дахин нэмэгдүүлж судалгаанд хамруулсан болно. Хамрах хүрээг өргөжүүлсэн үндэслэл нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагыг чиг үүрэг, тогтолцоогоор нь системтэй авч үзэх, түүнчлэн дээд шатны болон анхан шатны байгууллагын хоорондох ажлын уялдаа холбоо, иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмжийг цогц байдлаар олон талаас нь авч үзэх нь илүү үр дүнтэй гэж үзсэн.

Судалгаанд нийт 110 төрийн байгууллага, 110 албан тушаалтан, 110 ажилтан, 330 иргэнийг хамруулахаас:

- ажиглалтын судалгаанд 107 байгууллага,
- сурвалжлагын судалгаанд 104 албан тушаалтан, 106 ажилтан,
- төрийн байгууллагаас үйлчилүүгч 319 иргэн тус тус эхний шатанд оролцлоо.

Үүнд:

Татгалзсан байгууллага:

- Нийслэлийн ОБГ нь иргэдэд үйлчилдэггүй, тусгай статустай байгууллага учир аливаа нэгэн судалгаанд хамрагдах боломжгүй юм байна.
- ТӨХ нь төрийн мэдэлд байгаа өмчийн харилцааг зохицуулах бөгөөд иргэдтэй өдөр тутам шууд тулж ажилладаггүй тул иргэдээс судалгаа авах боломжгүй байлаа.
- ШБӨХЗГ нь иргэдтэй шууд харилцдаггүй бөгөөд зөвхөн монополь компаниудын хоорондын асуудлыг зохицуулдаг засгийн газрын тохируулагч агентлаг тул дээрхийн адил үйлчлүүлэх гэж очсон иргэн хараагүйгээс судалгаа авах боломжгүй байв.

Татгалзсан албан тушаалтнууд:

- БГД-ийн ШШГА-ны ахлах гүйцэтгэгч Ч.Оюунцэцэг “Манай байгууллагад АТГ-аас зөвлөмж ирээгүй тул судалгаа өгөхгүй” гэв.
- ГССҮТ-ийн дарга одоо завгүй байгаа тул судалгааг дараа өгье гээд дахин уулзах ба утсаар холбогдох боломж олгоогүй болно.
- БГД-ийн ТХ-ийн хэлтсийн дарга амарсан гээд нарийн бичгийн дарга нь судалгаанд хамрагдах боломжгүй гэсэн албан тоот хийж өгсөн.
- СБД-ийн Шүүхийн хяналтын прокурор Энхтуяа “Наад судалгаа чинь манай байгууллагатай ямар холбоотой юм бэ?, дүүргийн прокуророос очиж асуу. Даргын зөвшөөрөлгүй ямар ч судалгаа өгөхгүй, байгууллагадаа ч оруулахгүй” гээд судалгаа авахаар очсон мониторингийг харуулаа дуудаж хөөж гаргуулсан байна.
- СХД-ийн НДХ-ийн албан тушаалтан нь дарга амарсан тул энэ судалгаанд оролцох боломжгүй хэмээн албан тоот өгсөн болно.
- НОБГ-аас албан тушаалтан судалгаанд оролцоогүй.

Татгалзсан ажилтнууд:

- БГД-ийн ШШГА-ны ажилтан даргын зөвшөөрөлгүйгээр судалгаанд хамрагдах боломжгүй хэмээв.
- СХД-ийн НДХ-ийн албан тушаалтан судалгаанд оролцохгүй хэмээн албан тоот өгсөн тул ажилтан нь мөн хамрагдаагүй болно.
- ГССҮТ-ийн дарга судалгаанаас татгалзсан тул ажилтан нь мөн адил боломжгүй гэсэн хариу өглөө.
- НОБГ-ын ажилтнаас судалгаа авах боломжгүй байлаа.

1977 шууд утасны судалгаанд өнгөрсөн долдугаар сард 46 гомдол, 4 санал, наймдугаар сард 83 гомдол, 6 саналыг иргэдээс ирүүллээ.

Мониторингийн хугацаа

Мониторингийн судалгаа 2007 оны 07 сарын нэгнээс 2007 он дуустал зургаан сарын хугацаанд үргэлжилнэ. Мониторингийн тандалт, сурвалжлагын мэдээллийг найм, аравдугаар саруудад цуглуулж, суурь мэдээллээ бүрдүүлэн 2 удаа судалгааны явцын үр дүнг хэвлэлийн бага хурлаар дамжуулан олон нийтэд мэдээлж, ингэснээр төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойр болгоход төрийн байгууллагын анхаарлыг хандуулахад хувь нэмрээ оруулах юм.

Мониторингийн эхний шатны судалгааг 2007 оны 8-р сарын 06–10–ны хооронд ажлын таван өдөрт багтаан, нийслэл хотод байршилтай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий эрхийнхээ дагуу улс, нийслэл, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хийлээ.

Бичиг баримтын шинжилгээгээр дамжуулан, байгууллагын чиг үүргийг судлах ажлыг төсөл эхэлснээс хойшхи хоёр сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

1977 шууд утасны судалгаа нь 2007 оны 7 дугаар сарын еснөөс эхэлж, энэ оны 12 сар дуустал үргэлжилнэ.

3. МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН

3.1 Шууд утасны судалгаа /07-08 дугаар сарын байдлаар/

Төслийн хүрээнд төрийн байгууллагуудын зүгээс иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи иргэдийн санал, гомдлыг хүлээн авах АТГ-ын 1977 (энгийн утасны тарифтай) шууд утсыг 07-р сарын 09-нөөс нээлттэй ажиллуулж байгаа ба ирсэн мэдээллийг 7 хоногийн лхагва, баасан гарагуудад нэгтгэж, АТГ-т хүргүүлж байна.

АТГ эдгээр гомдлыг судлаж үзээд, тухайн гомдолд дурьдагдсан байгууллага, албан тушаалтанд зөрчлөө нэн даруй арилгаж, арга хэмжээ авахыг сануулсан шаардлага хүргүүлж, улмаар ямар арга хэмжээ авсан тухайгаа АТГ-т эргээд мэдээлэх үүрэг өгөн ажиллаж байна. Утасны судалгааны үр дүнг АТГ болон “Глоб Интернэшнл” ТББ-ын вэб сайтаар дамжуулан олон нийтэд сар тутам танилцуулж байна.

Өнгөрсөн хоёр сарын хугацаанд 1977 шууд утсаар төрийн байгууллагын албан тушаалтан, ажилтнуудтай холбоотой 129 гомдол, 9 санал ирүүлсэн байна. Гомдол ирүүлсэн иргэдийг харьяаллаар нь авч үзвэл 91 хувь нь УБ хотоос, үлдэх 9 хувь нь хөдөө орон нутгийн оршин суугчид байлаа.

ХХҮГ, ЭМБ, Боловсролын газар зэрэг төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, хэлтэс, салбарын дарга нар болон бүх шатны шүүгч, прокурор, мэргэжлийн хяналтын байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, цагдаа, гаалийн байцаагч зэрэг иргэдтэй шууд тулж ажилладаг төр захиргааны гүйцэтгэх албан тушаалтнууд, төрийн тусгай байгууллагын албан тушаалтнуудын үйл ажиллагаатай холбоотой гомдлууд үнэмлэхүй хувийг эзэлж байна.

07-р сарын байдлаар газрын албадад 14 хувь нь, нийслэл дүүргийн засаг даргын тамгын газруудад 29 хувь нь, шүүхийн шийдвэр биелүүлэх албадад 7 хувь нь иргэдийг чирэгдүүлж, зөрчил гаргажээ.

08-р сарын байдлаар 22 хувь нь засаг даргын тамгийн газруудад, 11 хувь нь замын цагдаагийн газруудад, 7 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлэх газруудад тус тус иргэдийг чирэгдүүлж, зөрчил гаргажээ.

Иргэд годол гаргасан үндэслэлээ 29 хувь нь хүнд суртал чирэгдэлтэй байдал, 27 хувь нь хуулийн дагуу асуудал шийдвэрлэж өгөхгүй байх, 18 хувь нь хууль дүрмийн хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удах, 11 хувь нь албан тушаалаа урвуулан ашиглаж, улсын болон бусдын эд хөрөнгийг завшиж байна хэмээн тус тус тайлбарласан байна.

Иргэдийн тодорхой хувь нь тухайн байгууллага, ажилтан, албан тушаалтанд хандаагүй боловч тэдний зөрчил гаргасныг харсан ба үүнийгээ гэрчилж чадна гэсэн байна. Иргэдээс НГА-ны ажилтан, албан тушаалтнуудад хандаж, зөвшөөрөлгүй байрилга барих, ашигт малтмалыг хууль бусаар хил давуулах мөн төрийн албан хаагчид хувьдаа их хэмжээний газар эзэмшиж, улмаар хувийн байшин бариулж буйг шалгаж өгөхийг ту тус хүссэн байна.

Түүнээс гадна өөрийн орны гаалийн татвараа хил залгаа орнуудын гаалийн татвартай харилцан уялдуулж тогтоох хэрэгтэй байна гэсэн санал ирлээ.

3.2. Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын мэдээллийн хүртээмжийг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

***Зөвлөмж-1:** Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах*

Судалгаанд хамрагдсан нийт 107 байгууллагын 54 хувь нь буюу 58 байгууллага дүрэм журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулсан байв. Мөн 9 яам, 10 агентлаг, 9 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 8 шүүх, прокурорын байгууллагуудад зөвлөмж-1-ийн хэрэгжилт сул байна. (Хүснэгт №3.1)

Төрийн байгууллагуудыг үйл ажиллагааных нь агуулгаар авч үзвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, санхүү, татвар, гаалийн байгууллагууд орж байна. Түүнчлэн нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд буюу дунд түвшний байгууллагуудад хэрэгжилт сул байгаа нь илүү ажиглагдав. Сүүлийн жилүүдэд иргэд ихээр үйлчлүүлэх болсон газрын албад, АМГТХЭГ-г хэрэгжилт тус тус сайн байна.

***Зөвлөмж-2:** Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих*

Зөвлөмж-2-ийн дагуу судалгаа хийхэд нийт байгууллагуудын 23 хувь нь тараах материал, 49 хувь нь танилцуулга гаргаж самбартаа хадсан байлаа. Тараах материал, танилцуулгын агуулгад зөвлөмжийн дагуу шинжилгээ хийхэд иргэдэд үйлчилгээ үзүүлэх албан тушаалтны чиг үүргийг тус зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа бүх байгууллагууд танилцуулгадаа оруулсан бол 83 хувь нь албан тушаалтны эрх хэмжээг, 81 хувь нь албан тушаалтнууд ямар үйлчилгээ үзүүлэх тухай, 87 хувь нь иргэдийн бүрдүүлж өгвөл зохих, шаардлагатай материалуудыг заажээ. Харин танилцуулгад албан тушаалтнууд хариуцсан үйлчилгээгээ ямар хугацаанд үзүүлэхийг 53 хувьд нь л дурьдсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт болж байна.

Тараах материал, танилцуулгын аль аль нь байхгүй яам 10, агентлаг 10, цагдаагийн хэлтэс 9, шүүх, прокурорын байгууллага 10 байв. (Хүснэгт №3.2)

Төрийн байгууллагаар үйлчлүүлэгч иргэдийн сурвалжлагын судалгаанд дөнгөж 15 хувь нь Шаардлагатай мэдээллийг авч чаддаг гэсэн бол 3 хувь нь үйл ажиллагаа нь доголдолтой, 82 хувь нь байхгүй, мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Үйлчлүүлэгч иргэдийн 4 хүн тутмын нэг нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа хэдий ч мэдээллийн самбар, танилцуулга байгаа эсэхийг ч огт сонирхож үздэггүй ажээ. Энэ нь нэг талаар иргэд самбар ашиглаж сураагүй нөгөө талаар самбар дээрх мэдээлэл нь иргэдийн хэрэгцээ хангаж чадахуйц түвшинд биш байгаатай холбоотой.

***Зөвлөмж-3:** Мэдээллийг вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган тараах*

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын 52 хувь нь вэб сайттай байсан бөгөөд, 36 хувь нь үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг хэвлэмэл материал тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага хэлбэрээр түгээж байсан ерөнхий тоог гаргавал эрх хэмжээгээр нь 2 агентлаг, 11 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 11 шүүх, прокурорын байгууллагууд иргэдийн шаардлагатай мэдээллийг вэб сайтаар түгээдэггүй. (Хүснэгт №3.3)

Бид байгууллагуудын вэб сайтад тавигдсан мэдээлүүд зөвлөмжийн дагуу шаардлага хангаж чадахуйц түвшинд байгаа эсэхийг мэдэх зорилгоор нягтлан үзэхэд 20 хүртэлх хувь нь эвдрэлтэй, ажиллахгүй байсан. Эрх хэмжээний хувьд дүүргүүд буюу анхан шатны байгууллагууд дээр тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна. Харин нийслэл буюу дунд шатны байгууллагуудад үзүүлэлт харьцангуй сайн байлаа. Үйл ажиллагааны агуулгаараа санхүү, татвар, гааль; хяналт шалгалт, бүртгэл, мэдээллийн; мөрдөх, цагдан сэргийлэх байгууллагууд дээр хэрэгжилттэй мөн сул байна.

Үйлчлүүлэгч иргэдээс тухайн байгууллага нь шаардлагатай мэдээллийг вэб сайтаар түгээж чадаж байна уу? гэсэн асуултад 7 хувь нь тийм гэж, 2 хувь өгч байгаа мэдээлэл нь дутагдалтай, 53 хувь нь өгч чаддаггүй гэж хариулжээ. Мөн эдгээр иргэдийн 40 орчим хувь нь вэб нь ямар мэдээлэлтэйг мэдэхгүй гэсэн байна. Энэ нь иргэд тэр бүр интернэт ашиглаад байдаггүй, нөгөө талаар тухайн байгууллагын вэб сайтын хаягийг мэддэггүй, вэб сайт дээр мэдээлэл нь иргэдийн хэрэгцээт хангаж чадахгүй байгаатай холбоотой.

Зөвлөмж-4: Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн самбарт болон вэб сайтад байрлуулах

Төрийн байгууллагуудын 64 хувь нь иргэдийг хүлээн авч, уулзах, цагийн хуваарийг гаргаж байгууллагын үйл ажиллагааны самбар /мөн вэб/-д байрлуулсан байсан бөгөөд 49 хувь нь иргэдтэй уулзах ажилтны овог, нэр, харилцах утсыг бичсэн байлаа.

Үүнд яам 6, агентлаг 1, дүүргүүдийн цагдаагийн хэлтэс 6, шүүх, прокурорын байгууллага 8 орж байна. Газрын албадыг онцолж харвал ганцхан СБД-ийнх л зөвлөмж-4-ийг хэрэгжүүлээгүй байна.

Нийслэл буюу дунд түвшний байгууллагууд дээр иргэдийг хүлээн авч, уулзах, цагийн хуваариа тодорхой гаргасан болон уулзах ажилтны овог нэр, харилцах утас зэргийг бичиж тэмдэглэсэн нь хангалтгүй байна. Хяналт шалгалт, бүртгэл, мэдээллийн болон эрүүл мэндийн байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна.

Үйлчлүүлэгч иргэдийн 20 хувь нь самбар дээр мэдээлэл байдаг, 4 хувь нь бусад газраас мэдээлэл авдаг, 16 хувь шаардлагатай мэдээлэл байдаггүй, 41 хувь нь самбар /вэб/ байхгүй, 20 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Ажилтны 3 хувь нь самбар ажилдаггүй гэсэн бол 86 хувь нь хариулт өгөхөөс татгалзжээ.

Албан тушаалтны хувьд 4 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Мөн л 89 хувь нь татгалзсан ажээ.

Зөвлөмж-5: Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох

Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизм нийт судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын 75 хувьд байна. Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдтэй хийсэн сурвалжлага судалгаа мөн иргэдийн утсаар

өгсөн мэдээлэл зэргээс үзвэл иргэдийн гомдол, саналыг хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удаадаг зөрчил дүүргийн газрын албад, цагдаагийн хэлтсүүд, засаг даргын тамгын газрууд, шүүхүүдэд нэлээд тохиолддог байна. Энэ нь хэдийгээр тухайн механизм нь байвч түүнийгээ ажиллуулж чадахгүй байгааг харуулж байна.

Үйлчлүүлэгч иргэдийн 12 хувь нь хариуцлага тооцох тал дээр муу ажилладаг, 18 хувь нь ийм механизм байдаггүй, үлдсэн 71 хувь нь мэдэхгүй гэж хариулсан.

Ажилтнуудын 4 хувь нь /1/ механизм байхгүй гэсэн бол 96 хувь нь /24/ ажилтан хариулсангүй.

Албан тушаалтны 95 хувь нь дээр зөвлөмжийн дагуух асуултад хариулахаас тэтгэлзсэн.

Зөвлөмж-6: *Иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрээ нийтэд вэб сайт болон бусад хэлбэрээр мэдээлж байх*

Судалгаанд хамруулсан нийт байгууллагын 52 хувь болох өөрийн вэбтэй гэх байгууллага бүр иргэдэд хэрэгцээтэй мэдээлэл, шийдвэр бүрээ вэбээрээ мэдээлдэг хэмээн хариулж байсан. Гэтэл гарсан шийдвэр, иргэдэд хамаатай мэдээллээ цаг хугацааны хувьд хожимдуулж гаргах, эсвэл бүр гаргахгүй байх явдал тохиолддог тухай иргэд ярьж байсан Ялангуяа анхан шатны байгууллагууд дээр харьцангуй их тохиолддог байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 24 байгууллагад 1 яам, 6 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 9 шүүх, прокурорын байгууллаг хамрагдаж байна. (Хүснэгт 1.5)

Иргэдийн 19 мэдээллэдэг, 5 энэ тал дээр муу ажилладаг, 19,0 мэдээлдэггүй, 76 хувь нь энэ тал дээр ямар нэгэн мэдээлэлгүй байна.

Ажилтны 8,6 хувь нь түгээж байгаа гэсэн бол 91,3 хувь нь хариулахаас татгалзсан.

Зөвлөмж-7: *Төрийн үйлчилгээний бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслан зогсоох*

Төрийн байгууллагуудын 56 хувь нь зөвлөмжийн дээрх заалтын дагуу арга хэмжээ авч эхэлсэн байна. Энэ талаар тухайн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдээс тодруулахад 43 хувь нь зохих ёсны дагуу харин 7 хувь нь тодорхой бус байдлаар төлбөр хураамж авч байна хэмээн тус тус хариулсан байна.

Мөн утсаар хандсан иргэдийн 9 хувь нь төрийн байгууллагууд үндэслэлгүйгээр нэмэгдэл төлбөр авдаг тул мэдээлжээ. Энэ тал дээр эрүүл мэндийн байгууллага, боловсролын байгууллага, засаг даргын тамгын газар, цагдаагийн хэлтсүүд иргэдийн гомдол, шүүмжлэлд өртсөөр байна.

Зөвлөмж-8: *Байгууллагуудын удирдлагын шийдвэртэй холбогдох материал, төсвийн зарцуулалт, албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогын мэдүүлэг гм/-ийг байгууллага бүр дотооддоо ил тод, нээлттэй болгох*

Байгууллагын удирдлагын шийдвэртэй холбогдох материалыг судалгаанд хамрагдсан нийт байгууллагын 62 хувь нь, байгууллагын төсвийн зарцуулалттай холбоотой мэдээллийг 38 хувь нь, байгууллагын албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогын мэдүүлэг гм/-ийг 41 хувь нь дотооддоо ил тод, нээлттэй болгосон байна. Гадаад харилцаа; хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллага; санхүү, татвар, гаалийн

байгууллага; байгаль орчныг хариуцах байгууллага; эрүүл мэндийн байгууллагууд дээр хэрэгжилт сул байна.

Тус зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллагуудын тоонд 3 яам, 4 агентлаг, 4 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 5 шүүх, прокурорын байгууллагууд орж байна. (Хүснэгт 1.6,7)

Ажилтны 90,4 хувь, албан тушаалтны 81 хувь нь хариулт өгөхөөс татгалзсан байна. Албан тшуаалтны 4,8 хувь нь Зарим мэдээлэл ил тод, 9,5 хувь нь хаалттай, 4,8 хув нь мэдэхгүй гэжээ.

Зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллагын 10 яам, 10 агентлаг, ЗДТГ-ууд, дүүргүүдийн татварын, даатгалын хэлтэс, замын болон цагдаагийн хэлтэс, шүүх, прокурорын системийн байгууллагууд зэрэг 63 байгууллага орж байна.

Зөвлөмж-9: Иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтдаа тавих, тавьсан мэдээллээ байнга шинэчилж байх

Судалгаанд хамрагсан нийт вэб сайттай байгууллагуудын 21 хувь нь тогтмол мэдээллээ шинэчилдэг, 20 хувь нь ажилладаггүй, 17 хувь нь шинэчлэл өөрчлөлт байхгүй, үлдсэн 45 хувь нь 2 сараас 2 жилийн өмнө л шинэчлэл хийсэн байлаа.

Тус зөвлөмжийг яам 5, цагдаагийн хэлтэс 7, эмнэлэг 7, шүүх прокурорын байгууллага 9 хэрэгжүүлээгүй байгууллагуудад багтаж байна. (Хүснэгт 1.8)

Судалгаанд хамрагдсан иргэдийн хэрэгцээт мэдээллийг вэб сайтдаа байрлуулсан бөгөөд мэдээллээ байнга шинэчилдэг үү гэсэн асуултад 20 хувь нь шинэчилдэг, 20 хувь нь үгүй, орж үзээгүй гэж 60 хувь нь хариултыг өгчээ.

3.3. Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлыг сайжруулахаар хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

Зөвлөмж-10. Үйл ажиллагааны нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 45 хувь нь үйл ажиллагааныхаа нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авч эхэлжээ. Тухайлбал судалгаанд хамруулсан байгууллагуудын 15 хувь нь иргэдийн бүрдүүлэх материалын тоо, дамжлагыг цөөрүүлсэн, 7 хувь нь энэ тал дээр санал боловсруулах шатандаа яваа зэрэг ахиц ажиглагдав. Боловсрол, эрүүл мэндийн байгууллага болон дүүргийн тамгын газруудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна.

Зөвлөмж-11. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн хариу өгөх

Иргэд, үйлчлүүлэгчдээс энэ талын мэдээллийг лавлахад 22 хувь нь үйлчилгээ /тухайн байгууллагын/ сайн, 12 хувь нь өмнөхөөсөө сайжирч байна, 5 хувь нь энэ асуудлыг хариуцсан тусгай нэг хүн байдаг, 32 хувь нь үйл ажиллагаа нь доголдолтой хэвээрээ байна, 30 хувь нь энэ талаар мэдэхгүй хэмээн хариулжээ. Шүүх, прокурорын байгууллага; нийгмийн хамгаалал, хөдөлмөр, даатгалын байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байна.

Тус зөвлөмжийг 9 яам, 4 агентлаг, 7 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 6 шүүх прокурорын байгууллага хэрэгжүүлээгүй. (Хүснэгт 1.9)

Гомдол хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж буй байдалд сайн гэсэн үнэлгээг иргэдийн 43 хувь, үйл ажиллагаа доголдолтой гэж 18 хувь, мэдэхгүй гэж 29 хувь нь үзжээ.

Зөвлөмж-12. Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэд, хуулийн этгээдэд нээлттэй болгох

Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнуудын хувьд байгууллагынх нь шийдвэр гаргах үйл ажиллагаа нээлттэй байдаг хэмээн 79 хувь нь, зарим талаар нээлттэй байдаг хэмээн 11 хувь нь хариулсан бол 8 хувь нь нээлттэй бус хэмээн үзжээ. Шийдвэрийн үндэслэл иргэдэд нээлттэй байх хэрэгтэй. Гэтэл үйлчлүүлэгчдийн бараг 68 хувь нь мэдэхгүй, байгууллагууд хэрэгжүүлдэггүй гэсэн хариултууд жин дарж байна, Харин нээлттэй байдаг хэмээн 29 хувь нь үзэж байна. Шүүх, прокурорын байгууллага; дэд бүтэц; байгаль орчныг хамгаалах байгууллага; боловсролын байгууллагад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байв.

Дээрх зөвлөмжийг 9 яам, 7 агентлаг, 7 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 4 эмнэлэгийн байгууллага хэрэгжүүлээгүй. (Хүснэгт 1.10)

Зөвлөмж-13. Төрийн байгууллага, албан тушаалтны ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар жил бүр тайлан гаргаж дүгнэж байх

Төрийн байгууллагуудын 51 хувь нь албан тушаалтны ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаар тогтмол тайлан, 4 хувь нь нэмэлт тайлан, 27 хувь нь гаргасан тайлангаа дүгнэдэг бол 7 хувь нь энэ асуудлыг тодорхой нэг албан тушаалтандаа хариуцуулдаг ажээ. Харин 2 хувь нь төрийн байгууллагын албан тушаалтны үйл ажиллагаа нээлттэй, ил тод, бүгд явцын хуралд суудаг учир тайлан гаргах шаардлагагүй, 0.5 хувь нь тайлан гаргадаггүй зэрэг хариултуудыг өгчээ.

Боловсролын байгууллага, нийгмийн хөдөлмөр, хамгаалал, даатгалын байгууллага, дэд бүтэц, хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллага; гадаад харилцааны байгууллагуудад тус зөвлөмжийн хэрэгжилт сул байв.

3.4. Авлигатай Тэмцэх Газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах чиглэлээр хүргэсэн зөвлөмжийн хэрэгжилт

Зөвлөмж-14. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад иргэд чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх

Төрийн байгууллагуудаас үйлчилгээ авч байсан иргэдийн 80 хувь нь тухайн байгууллагад нэвтрэхэд нь ямар нэгэн саад байдаггүй гэсэн байхад 15 хувь нь дүрэм журамд заасных нь дагуу шаардлагатай бичиг баримт /ихэнх тохиолдолд биеийн байцаалт/-аас шалгуулж орсон байна. Харин 5 хувь нь ороход нь бэрхшээлтэй эсвэл орж чаддаггүй гэсэн хариулт өгчээ.

Зөвлөмж-15. Иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах, эсхүл санал хүсэлтийн хайрцаг/дэвтэр/-ийг байрлуулан иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах

Иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын 60 хувь нь иргэдээс мэдээлэл хүлээн авах утас ажиллуулдаг хэмээн судалгаанд хариулт өгсөн юм. Үүнийг бид үйлчлүүлэгч иргэдээс тодорлуулахад нийт иргэд, үйлчлүүлэгчдийн 6 хувь нь л утсаар хандаж байсан байна. 36 хувь нь ажиллуулдаг гэдгийг нь мэдэх боловч хандаж байгаагүй, 57 хувь нь ажиллуулдаггүй буюу мэдэхгүй гэж хариулсан. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр даатгалын байгууллага; хяналт шалгалт, бүртгэл, мэдээлийн байгууллага; тамгын газруудад хэрэгжилт сул байв.

Мөн дээрх байгууллагуудын 37 хувь нь санал хүсэлтийн хайрцаг ажиллуулдаг байна. Үүнийг үйлчлүүлэгч иргэдийн 1 хувь нь ашиглаж байсан, 16 хувь нь байдаг гэдгийг нь мэдэх хэдий ч ашиглаж байгаагүй, 83 хувь нь ашиглаж байгаагүй, мэдэхгүй гэсэн хариулт өгсөн. Гадаад харилцааны байгууллагууд; дэд бүтцийг хангах байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Байгууллагуудын 26 хувь нь дэвтэр гаргаж ажиллуулдаг. Гэтэл иргэдийн 2 хувь нь л түүнийг ашиглаж байсан, 26 хувь нь ажиглуулдаг гэдгийг мэдэх хэдий ч ашиглаж байгаагүй, 78 хувь нь ажиллуулдаггүй, мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, даатгалын байгууллага; боловсролын байгууллага; газар, ашигт малтмалыг зохицуулах байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Мөн нийт байгууллагын 69 хувь нь иргэдээс мэдээлэл хүлээн авах утас /санал хүсэлтийг хайрцаг/дэвтэр/-ийг байгууллагад байрлуулдаг иргэдийн санал, хүсэлтийг авч, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах механизм байдаг хэмээн хэлсэн. Шүүх, прокурорын байгууллагуудад хэрэгжилт сул байв.

Зөвлөмж 15-ийг огт хэрэгжүүлээгүй байгууллагад яам 8, агентлаг 4, шүүх 8 байгууллага хэрэгжүүлээгүй. (Хүснэгт 1.12)

Зөвлөмж-16. Төрийн байгууллага тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн санал бодлыг авч, анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох

Төрийн байгууллагуудын хувьд 51 хувь нь тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн саналыг авдаг, эдгээрийн 60 хувь нь олон нийтийн саналыг авахын өмнө анхаарал татаж байгаа мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгадаг гэсэн хариулт өгсөн юм.

Гадаад харилцааны байгууллага; Шүүх, прокурорын байгууллага; Хүнс, худалдаа үйлдвэрлэлийн байгууллагуудад хэрэгжилт сул байв. Тиймээс энэ нь эргэлзээтэй мэдээлэл юм.

Тус зөвлөмжийг яам 3, агентлаг 3, цагдаагийн хэлтэс 3, эмнэлэг 4, шүүх, прокурорын байгууллага 9 тус тус хэрэгжүүлээгүй. (Хүснэгт 1.13)

Зөвлөмж-17. Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, тэдгээртэй танилцах боломжоор хангах

Төрийн байгууллагуудын 8 хувь нь хууль тогтоомжид тус байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шаргаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хориглосон байдаг, 92 хувь нь зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод байлгаж, танилцах боломжоор хангасан байлаа. Гадаад харилцааны байгууллага; Газарын албад, АМГТХЭГ; Мөрдөн шалгах, цагдаагийн байгууллага; тамгын газруудад хэрэгжилт сул байна.

Тус зөвлөмжийг 4 яам, 5 агентлаг, 10 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 4 эмнэлэг, 9 шүүх, прокурорын байгууллага хэрэгжүүлээгүй. (Хүснэгт 1.14)

Мөн тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг олон нийтэд ил тод нээлттэй байлгадаг гэж иргэдийн 19 хувь нь, 33 хувь нь өмнөхөө бодвол сайжирсан, 33 хувь нь нээлттэй биш, 45 хувь нь мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн. Шүүх, прокурорын байгууллагууд; Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, даатгалын байгууллага; Мөрдөн шалгах, цагдаагийн байгууллагуудад хэрэгжилт сул байна.

Зөвлөмж-18. Байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийг боловсронгуй болгож, тэр дундаа ямар ёс зүйг ажилтнууд сахих талаарх заалтуудыг иргэдэд нээлттэй болгох

Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагуудын 55 хувь нь ажилтнуудынхаа ёс зүйн заалтуудыг иргэдэд нээлттэй болгосон байна. Иргэд, үйлчлүүлэгчдийн 16 хувь нь ажилчдын иргэдтэй харьцах харьцаа нь сайн, ажилтнуудын ёс зүй нээлттэй ил тод байдаг; 46.5 хувь нь хаалттай, 27 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байна. Гадаад харилцааны байгууллага; Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжилт сул байна.

Тус зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгууллагуудын тоонд 11 яам, 4 агентлаг, 5 дүүргүүдийн цагдаагийн хэлтэс, 6 шүүх прокурорын байгууллагууд орж байна. (Хүснэгт 1.15)

4. Дүгнэлт, санал

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллагуудад АТГ-аас байгууллагуудын мэдээллийн хүртээмжтэй, ил тод байдал, иргэдийн оролцоог хэрхэн хангах талаар зөвлөсөн 18 зүйл бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэх суурь боломж болон механизм байгаа гэж үзэж байна.
- Үүний нэг жишээ нийт байгууллагуудын 52 хувь нь вэб сайттай байгаа боловч тэдгээр байгууллагуудын 21 хувь нь л тогтмол мэдээллээ шинэчилдэг, дээр нь нийт вэб сайтын 20 хувь нь ажиллагаагүй, 17 хувь нь шинэчлэл өөрчлөлт байхгүй, үлдсэн 45 хувь нь 2 сараас 2 жилийн өмнөх мэдээлэлтэйгээ байв.
- Байгууллагуудыг үйл ажиллагааных нь цар хүрээгээр авч үзвэл улсын болон нийслэлийн хэмжээний байгууллагууд вэб сайтаар мэдээлэл түгээх нь илүү байна. Дүүргийн албад, хэлтсүүдийн дийлэнх нь иргэдэд зориулсан мэдээллээ тухайн дүүргийнхээ вэбэд болон үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу өөрийн удирдах байгууллагуудын вэбэд байрлуулсан боловч уг мэдээллүүд нь чанарын шаардлага хангахуйц байж чадахгүй байна.
- Анхан шатны байгууллагууд сайтаас бусад жишээлбэл танилцуулгын самбар, тараах материал ашиглах нь түлхүү харин улсын болон нийслэлийн хэмжээний байгууллагуудад вэб сайтаар мэдээлэл түгээх хэлбэр түгээмэл байв.
- Ерөнхийдөө байгууллагууд вэб сайт, самбар, зурагт хуудас болон тараах материал зэргийг иргэдэд мэдээлэл түгээх 3 нийтлэг хэлбэрийг сонгож авчээ.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй байдлын суурь боломж 69 хувьтай байна. Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаагаа дотооддоо, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй болгох тал дээр шүүх, прокурор, даатгалын байгууллагууд, үйл ажиллагааны нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм журмаа өөрчлөх тал дээр боловсрол, эрүүл мэнд, дүүргийн тамгийн газарууд, байгууллага албан тушаалтны ажиллагаанд ил тод байдлыг хэрхэн хангасан талаарх тайлан гаргах тал дээр хөдөлмөр хамгаалал, даатгал, дэд бүтцийг хангах, хүнс худалдаа үйлдвэрлэл, гадаад харилцааны байгууллагууд тус тус хангалтгүй ажиллаж байна.
- 1977 утсанд хандсан иргэдийн гомдол саналыг нэгтгэн анализ хийж үзэхэд дүүргүүдийн газрын албад, бүх шатны шүүх, замын цагдаагийн газар албад, хөдөлмөр халамж үйлчилгээний газар албад, эрүүл мэндийн байгууллагууд болон нийслэлийн боловсролын газарт зөвлөмжийн хэрэгжилт ихээхэн хангалтгүй байна. Судлагааны үр дүнгээс эдгээр байгууллагуудын дээд удирдлага, албад, хэлтэс салбарын дарга нар болон бүх шатны шүүгч, прокурор, мэргэжлийн хяналтын байцаагч зэрэг иргэдтэй шууд харьцаж ажилладаг төр захиргааны гүйцэтгэх ажилтууд, төрийн тусгай байгууллагуудын албан тушаалтан хүнт сурталтай, иргэдийг ихээр чирэгдүүлж буй нь харагдаж байгаа бөгөөд тэдний үйл ажиллагаатай холбоотой гомдол үнэмлэхүй хувийг эзэлж байна.
- Иргэдээс мэдээлэл хүлээж авах утас төрийн байгууллагуудын 60 орчим хувь нь байдаг боловч иргэдийн 43 орчим хувь нь иргэдээс мэдээлэл авах утас ажиллуулдагыг мэддэг, 57 орчим хувь нь байхгүй буюу энэ талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй гэж хариулсан. Утас ажиллуулдагийг мэддэг иргэдийн 13 хувь нь л тухайн утсанд хандаж гомдол, санал гаргаж байсан байна.
- Судалгааны эхний хагасын дүнг харахад 2007 оны 4 сард хүргэсэн АТГ-ын зөвлөмж мартагдах дөхжээ. Зөвлөмжийг хүргүүсэн зарим газруудад тус зөвлөмжийн талаар огт сонсоогүй албан хаагчид олон байна. Төрийн байгууллагууд нь өөрөө хатуу бюрократ бүтэцтэй байдаг бөгөөд байгууллага дахь ямарваа статус бүр өөр өөрийн үүрэгтэй байдаг. Иймд тухайн байгууллагад аливаа

- албан ёсны статусгүй зөвлөмж үйл ажиллагааны явцад явцад сугарч үлдэх, мартагдах явдал болж байдгийн нэгэн жишээ болж байна. Тиймээс байгууллага бүрд АТГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг тухайлсан албан хаагчид үүрэг хэлбэрээр давхар хариуцах нь зүйтэй.
- Төрийн байгууллагуудад тогтмол хяналт, шалгалтын механизм өгүүлэгдэж байна. АТГ хүргүүлсэн зөвлөмжийнхөө хэрэгжилтийг хянах, мөн хяналтгүй байгаа байгууллагуудад анхааруулга өгөх зэргээр үйл ажиллагаагаа идэвхжүүлэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ -1

Мэдээлэл хүртээмжтэй байх талаар

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газарт байрлуулах
- Иргэд, хуулийн этгээдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хүргэдэг төрийн албан тушаалтны чиг үүрэг, эрх хэмжээ, ямар үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг үйлчлүүлэгчдэд тараах, эсхүл тэдэнд харагдахаар газарт бичиж тавих
- Мэдээллийг вэб сайтаар түгээхийн зэрэгцээ хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган тараах
- Иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн самбарт болон вэб сайтад байрлуулах
- Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох
- Иргэд, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрээ нийтэд вэб сайт болон бусад хэлбэрээр мэдээлж байх
- Төрийн үйлчилгээг бүх төрлийн төлбөр, хураамжийг бодитой тогтоох, үндэслэлгүйгээр илүү болон нэмэгдэл төлбөр, хураамж авах асуудлыг таслан зогсоох
- Байгууллагын удирдлагын шийдвэртэй холбогдох материал, төсвийн зарцуулалт, албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогийн мэдүүлэг гэх мэт/-ийг байгууллага бүр дотооддоо ил тод, нээлттэй болгох
